Эрдэс баялгаас
эрдэм мэдлэг, ур чадвар,
үнэт зүйлс бүтээлцэнэ

Оюу Толгой

# МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2020 оны I улирлын тойм мэдээ

OTMongolia | OTMongolia | OyuTolgoi | OTMongolia | OTMongolia

## АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Аюулгүй ажиллагаа нь бидний нэн тэргүүний зорилт. Аюултай гэж үзсэн ямар ч ажлыг ажилтан бүр **зогсоох** эрхтэй.

2020 оны I улиралд
7,832,622
Хүн/цаг

Гүйцэтгэл
0.20

2020 оны нэгдүгээр улиралд 200,000 хүн/цаг тутамд ногдох гэмтэл, бэртлийн давтамжийн үзүүлэлт 0.20 байлаа.

Ноцтой эрсдэлийн удирдлага
53,893
Магадлагаа

2020 оны нэгдүгээр улиралд амь хамгаалах зорилготой "Ноцтой эрсдэлийн удирдлага" хөтөлбөрийн хүрээнд 58,893 магадлагаа хийлээ.

## МОНГОЛ АЖИЛТНУУДЫН ЭЗЛЭХ ХУВЬ

Үүрэг 90%

94%

Нийт ажиллах хүчний 94 хувийг монголчууд бүрдүүлж байна. Харин гүний уурхайн төсөлд нийт ажилтнуудын 56 хувь нь ажиллаж байна.

## БОЛОВСРОЛ СУРГАЛТ

(Нийт хүн/цаг)

131,936

Компанийн алсын хараaны хүрээнд 2020 оны нэгдүгээр улиралд 131,936 хүн/цагийн сургалт хийж, ажилтнуудынхаа ур чадварыг нь өсгөсөөр байна.

**БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР**
(Тэтгэлэг, бусад хөтөлбөрүүд)
2011 оноос хойш **2600** оюутан

**ЗАЛУУСЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР**
2013 оноос хойш ахлах ангийн **1095** сурагч

**"ГОВИЙН ОЮУ" САНГИЙН ТЭТГЭЛЭГ**
2015 оноос хойш Өмнөговийн **320** оюутан тус тус хамрагджээ.

## ҮНДЭСНИЙ ХУДАЛДАН АВАЛТ

(2010-2020/01 улирал, сая ам.доллар)




2020 оны I улиралд үйл ажиллагааны худалдан авалтын баг 516 ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласны 361 нь үндэсний компаниуд байв. Эдгээр үндэсний компанид худалдан авалтынхаа 75 хувийг зарцуулав. 2010-2020 оны I улирлын хооронд үндэсний худалдан авалтад 3.3 тэрбум ам.доллар зарцуулсан.

## УСНЫ ХЭРЭГЛЭЭ

(Нэг тонн хүдэр боловсруулахад зарцуулсан усны хэмжээ, шоо метр, сараар)




## УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

(2013-2020/01 улирал)

104
тэрбум төгрөг

## УС ДАХИН АШИГЛАЛТ

(хувь, сараар)




87%

2020 оны эхний улиралд ус дахин ашиглалтын түвшин 80 хувийн зорилтоо давуулан биелүүлж, 87 хувьд хүрэв.

* Бүртгэлийн програм хангамжийн хооронд мэдээлэл зөөвөрлөхөд хийгдсэн дутуу тооцооллын улмаас 2012 оны үндэсний худалдан авалтын дүн 305 сая ам.доллар гэж тайлагнасныг залруулж 312 сая ам.доллар болгон шинэчилсэн. Энэхүү залруулга нь зөвхөн Тойм мэдээнд хамааралтай бөгөөд Оюу толгойн санхүүгийн тайланд нөлөөлөхгүй.

# МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2020 оны I улирлын тойм мэдээ

OTMongolia OTMongolia OyuTolgoi OTMongolia OTMongolia

## ТАТВАР, ХУРААМЖ, БУСАД ТӨЛБӨР

(2010-2020/01 улирал, сая ам.доллар)




2010-2020 онд өсөн нэмэгдсэн дүнгээр

**2.7**

**ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫГ** татвар хураамж, бусад төлбөрт төлжээ.

2010 - 2020 оны I улирлын хооронд 2.7 тэрбум ам.долларыг татвар, хураамж, үндсэний компаниуд төлсөн НӨАТ зэрэг бусад төлбөрт төлсөн. Үүнээс 73 сая ам.долларыг 2020 оны эхний улиралд төлжээ.

** "Оюу толгой" ХХК НӨАТ-ын буцаан авалт хийдэггүй.*

## ДОТООДОД ЗАРЦУУЛСАН НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГӨ

(2010-2020/01 улирал, тэрбум ам.доллар)

2010-2020 оны I улирлын хооронд үндэсний компаниудтай хийсэн худалдан авалт, төсөвт төлж буй татвар, хураамж, үндсэн ажилчдын цалин 10.7 тэрбум ам.доллар давлаа.




## ОРОН НУТГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

(сая ам.доллар)




2020 оны эхний улиралд тогтвортой хөгжилд чиглэсэн төслүүдэд 5.2 сая ам.долларын санхүүжилт олгожээ.

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХИЙСЭН ХУДАЛДАН АВАЛТ

(2010-2020/01 улирал, сая ам.доллар)




2020 оны I улиралд Өмнөговь аймагт бүртгэлтэй 69 ханган нийлүүлэгчээс 584 сая ам.долларын бараа, үйлчилгээ авлаа.

## ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ ЗЭСИЙН ХЭМЖЭЭ

(мян.тонн)




2020 оны эхний улиралд 35,200 тонн баяжмал дахь зэс үйлдвэрлэв. 140,000 – 170,000 тонн баяжмал дахь зэс үйлдвэрлэх жилийн төлөвлөгөөний биелэлт хангалттай байна.

## ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ АЛТНЫ ХЭМЖЭЭ

(мян.унц)




2020 оны эхний улиралд 26,200 унц баяжмал дахь алт үйлдвэрлэв. 120,000-150,000 унц баяжмал дахь алт үйлдвэрлэх төлөвлөгөөний биелэлт хангалттай байна.

## ГҮНИЙ УУРХАЙН ХӨНДЛӨН НЭВТРЭЛТ

(метр, сараар)




2020 оны эхний улиралд гүний уурхайн хөндлөн малталтын гүйцэтгэл 5,466.3 метр, харин налуу амны малталтын ажил 1,013.7 метрийн ахицтай байлаа.

Оюу Толгой